



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/220

Номгон

Г

Г

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад зохион
байгуулагдах "Canton fair 2026" Олон Улсын
үзэсгэлэнд Баянхонгор аймгийн төлөөлөгчдийг
оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.14, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 90 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэвэр, үр ашигтай халаалтын системийг орон нутагт нэвтрүүлэх, баталгаат үйлдвэрлэгчтэй шууд холбогдох, импорт экспортын бодит үнэ, зах зээлийн чиг хандлагыг газар дээр нь судлах, урт хугацааны хамтын ажиллагааны түншлэл эхлүүлэх өргөн боломжийг судлах зорилгоор Баянхонгор аймгийн төлөөлөгчдийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гуанжоу хотод 2026 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулагдах "Canton fair 2026" олон улсын үзэсгэлэнд оролцуулсугай.

2.Олон улсын үзэсгэлэнгийн арга хэмжээнд Баянхонгор аймгаас оролцох төлөөлөгчдийн нэрсийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээнд оролцоход шаардагдах зардал 36,073,200 (Гучин зургаан сая далан гурван мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний зардлаас, 5,446,800 (Таван сая дөрвөн зуун дөчин зургаан мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус


626010583

санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Олон Улсын үзэсгэлэнгийн арга хэмжээнд идэвхтэй оролцож, цэвэр, үр ашигтай халаалтын системийн талаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, сүүлийн үеийн технологи, инновацтай танилцаж сайн туршлагыг орон нутагт нэвтрүүлэх боломжийн талаар судлан, танилцуулж ажиллахыг арга хэмжээнд оролцох төлөөлөгч нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ